



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2008 оны 11 сарын 05 өдөр

Дугаар 477

Улаанбаатар хот

Сургалтын төлбөрийг сургалтын
төрийн сангаас санхүүжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгуулагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улс атар газар эзэмшсэний 50 жилийн ой, Атрын гуравдугаар аяныг Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэний хоёр дахь жилийн хүрээнд зохион байгуулагдсан "Атрын-3" реалити шоунд оролцон, ажил хөдөлмөрийн амжилтаар манлайлан эхний гурван байр эзэлсэн Шинжлэх ухаан, технологийн сургуулийн оюутан Н.Мөрөнбор (хувийн дугаар 07), Кино урлагийн дээд сургуулийн оюутан А.Энхжин (хувийн дугаар 06), Идэр дээд сургуулийн оюутан Д.Лхагвасүрэн (хувийн дугаар 10) нарын 2009-2010 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг Сургалтын төрийн сангийн санхүүжилтээс буцалтгүй тусламжаар олгохыг зөвшөөрсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол улсын болон гадаадын дээд боловсролын сургалтын байгуулагад суралцагчдад төрийн буцалтгүй тусламж олгох журам"-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Е.ОТГОНБАЯР